



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 29 өдөр

Дугаар

A/34

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1 Соёлын яамнаас эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Кино театрын барилга (Ховд, Жаргалант сум)-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ж.Батсайхан - Тогтвортой амьжиргаа” төслийн зохицуулагч

Гишүүдэд: Х.Баярлах - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Дэлгэрмаа - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ц.Бат-Эрдэнэ - Иргэний төлөөлөл

Нарийн бичиг: Х.Дэмид - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Ж.Батсайхан)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Х.Дэмид)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД